



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ОДОН ОРОН ГЕОФИЗИКИЙН ХҮРЭЭЛЭН
2017 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН,
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТ

Аудитын код: САГ-2018/200/СТА-ТШЗ

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ХЯЗГААРЛАЛТАЙ
САНАЛ ДҮГНЭЛТ



**МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2018.02.23 № 06/428
таний _____ -ны № _____ -Т

**ОДОН ОРОН ГЕОФИЗИКИЙН
ХҮРЭЭЛЭНГИЙН ЗАХИРАЛ
С.ДЭМБЭРЭЛ ТАНАА**

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Одон орон геофизикийн хүрээлэнгийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Одон орон геофизикийн хүрээлэнгийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Одон орон геофизикийн хүрээлэнгийн 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйцээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн төрийн аудитын байгууллага програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн төмөрхөн тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох үйлсүүд хэд хэд тусгай үнэмлэсэн.

**01 ХЯЗГААРЛАЛТТАЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.



Аудитын гол асуудал

Одон орон геофизикийн хүрээлэнгийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд үндсэн хөрөнгийн дахин үнэлгээг (14,264.1) мянган төгрөгөөр тайлагнасан, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй 182,766.9 мянган төгрөгийн авлагыг бүртгэсэн зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ХЯЗГААРЛАЛТАЙ
САНАЛ ДҮГНЭЛТ



YAG
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**ОДОН ОРОН ГЕОФИЗИКИЙН ХҮРЭЭЛЭН
2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Аудитын код: САГ-2018/200/СТА-ТШЗ

АУДИТЫН ТАЙЛАН

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:**

САГ-ын захирал, Тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663
Цахимхаяг: naranchimegts@audit.mn

Аудитын менежер: С.Оюунгэрэл
Утас: 261885
Цахимхаяг: oyungerels@audit.gov.mn

ТАБ-ын хаяг: ЗГ-ын IV байр
Бага тойруу 6, Улаанбаатар 46
Цахим хуудас: www.audit.mn

“Цэгцтөв богд Аудит” ХХК-ийн
Аудитын багийн ахлагч Н.Цэрэнханд
Утас:99901517

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт 5: Аудит хийсэн төсвийн
гүйцэтгэлийн тайлан

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
**ХЯЗГААРЛАЛТАЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

Агуулга

1. АУДИТЫН ГЭРЧИЛГЭЭ	1
2. АУДИТЫН ТАЙЛАН	1
2.1 Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл	1
2.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	1
2.3 Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн	2
2.4 Материаллаг байдлын түвшин	3
2.5 Дотоод хяналт	3
2.6 Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар	3
2.7 Шилэн дансны мэдээлэл	4
2.8 Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар	4
2.9 Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар	4
2.10 Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар	5
2.10.1 Авлагын талаар	5
2.10.2 Бараа материалын талаар	5
2.10.3 Үндсэн хөрөнгийн талаар	6
2.10.4 Хөрөнгийн дахин үнэлгээний талаар	6
2.10.5 Зардлын талаар	6
2.10.6 Цалин хөлсний талаар	7
2.11 Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар	8
2.12 Анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.13 Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд	8
2.14 Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	8
2.15 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	8
2.16 Хязгаарлалттай санал дүгнэлт	8
3. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ	11
3.1 Авлагын талаар	12
3.2 Бараа материалын талаар	2
3.3 Үндсэн хөрөнгийн талаар	3
3.4 Хөрөнгийн дахин үнэлгээний талаар	3
3.5 Зардлын талаар	14
4. АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	16
4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	16
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	18
4.3 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	20
4.4 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	21
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	23

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ХЯЗГААРЛАЛТАЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

2. АУДИТЫН ТАЙЛАН

2.1 Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Одон орон геофизикийн хүрээлэнгийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитыг Төрийн аудитын тухай, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Одон орон геофизикийн хүрээлэнгийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн гаргасан Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, программ хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Одон орон геофизикийн хүрээлэнгийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитыг 2018 оны 01 дүгээр сарын 25-аас 2018 оны 02 дугаар сарын 14-ныг хүртэл хийхээр төлөвлөн "Цэгцтөв богд аудит" ХХК-ийн 2 дугаар багийн аудитор Д.Болормаа, аудиторын туслах ажилтан Х.Уранчимэг нар хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Одон орон геофизикийн хүрээлэн 2017 оны санхүүгийн тайланг хугацаа хоцроож 2018 оны 01 дүгээр сарын 31-нд "Цэгцтөв богд аудит" ХХК-д ирүүлсэн байна.

"Цэгцтөв богд аудит" ХХК нь аудитыг 2018 оны 01 дүгээр сарын 31-нээс 2018 оны 02 дугаар сарын 14-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг хуулийн хугацаанд Одон орон геофизикийн хүрээлэнгийн удирдлагад гардуулна.

2.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Одон орон геофизикийн хүрээлэнгийн төсвийн захирагч нь Монгол Улсын Төрийн аудитын тухай, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн албаны тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Төрийн болон орон нутгийн

өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай, Шинжлэх ухаан технологийн тухай, ШУА-ийн эрх зүйн байдлын тухай, Хөдөлмөрийн тухай, Соёлын тухай, Нийгмийн даатгалын тухай, ХХОАТ-ын тухай, Шилэн дансны тухай хуулиуд болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан, тодруулгын маягт, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлал", "Эдийн засгийн ангилал батлах тухай" зэрэг эрх зүйн актуудыг мөрдөж байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Тус хүрээлэнгийн дүрмээр хүлээсэн чиг үүргүүдтэй танилцав. Одон орон, геофизикийн хүрээлэнг 1997 онд Астрономи, геофизикийн зангилаа асуудлыг орчин үеийн шинжлэх ухааны төвшинд судлан боловсруулах үйл ажиллагаа явуулах чиглэлээр байгуулж, Шинжлэх ухааны академийн харъяанд салбарын шинжлэх ухааныг хөгжүүлэх, судалгаа боловсруулалтын ажил эрхлэх, төсөл хэрэгжүүлэх инновацийг бий болгож, үр дүнг нэвтрүүлэхээр үндсэн зорилгыг тодорхойлсон байна.

Уг хүрээлэн нь Одон орон судлал, Геофизикийн судлалын чиглэлийн 2 салбарт нийт 200 гаруй ажилтантай ажилладаг байна. Одон орон судлалын салбар нь астрометр, геодинамикийн судалгааны ба нарны физикийн секторууд, геофизикийн салбар нь газар хөдлөл болон орон нутгийн газар хөдлөлтийг бүртгэх станцууд ба геосоронзон судлалын сектороос бүрджээ.

Одоогийн бүтэц, зохион байгуулалтын хүрээнд эрхэм зорилго, зорилтоо тодорхойлон үйл ажиллагаагаа явуулж байна.

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д "Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна" гэж заасны дагуу төсвийн шууд захирагч нь хүрээлэнгийн зорилгыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Одон орон геофизикийн хүрээлэнгийн үйл ажиллагааны талаар ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

2.3 Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын зорилго, зүйл, хэрэгжүүлсэн төрлөөр, хяналтын сорил болон нарийвчилсан гэрим, түүний үр дүн

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Одон орон геофизикийн хүрээлэнгийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

01

ХЯЗГААРЛАЛТАЙ
САНАА ДҮГНЭЛ

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

01

ХЯЗГААРЛАЛТАЙ

тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 44-ыг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад Одон орон геофизикийн хүрээлэнгийн санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг БСШУС сайдын 2017 оны А/40 дугаар тушаалаар батлан 2017 оны 01 дүгээр сарын 01-ээс эхлэн мөрдөн ажиллахыг үүрэг болгосон байна. Энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичигт нягтлан бодох бүртгэлийн бодлого мөн Зөрчлийн тухай хууль, Засгийн газрын тогтоолууд Сангийн яамнаас батлагдан гарсан журмуудын өөрчлөлтийг тусгасан боловч тухайн байгууллагын үйл ажиллагааны онцлогийг харуулаагүй байна.

Бид Одон орон геофизикийн хүрээлэнгийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерын системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэн оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Одон орон геофизикийн хүрээлэн санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг Санхүүгийн тооцоолох групп ХХК-ийн төсөвт байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн Acolous, цалингийн Payroll програмуудаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг бэлтгэсэн байна.

2.4 Материаллаг байдлын түвшин


Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг тайлант оны орлого, үр дүнгийн тайлангийн нийт зардал 4,113,282.4 мянган төгрөгийн 2 хувиар тогтоож, хүлээн зөвшөөрөх алдааны түвшинг 82,265.6 мянган төгрөг гэж тооцов.

2.5 Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

2.6 Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар

2017 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу, Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлж, төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулан, төсвийн санхүүжилтийг батлагдсан хуваарийн дагуу зардлын зүйл ангиар зарцуулж, гүйцэтгэлд нь хяналт тавьж ажилласан байна.



Одон орон геофизикийн хүрээлэн 2017 онд улсын төвлөрсөн төсвөөс 2,400,466.6 мянган төгрөг, бараа үйлчилгээний орлого 116,922.5 мянган төгрөгийг олж үүнээс урсгал зардалд 2,517,398.2 мянган төгрөгийг зарцуулсан байна. Дээд шатны төсвийн байгууллагаас нэмэлт санхүүжилтээр 520,870.5 мянган төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд буй болсон нэмэлт орлого 34, 987.6 мянган төгрөг буюу нийт 555,858.1 мянган төгрөгийн орлогыг бий болгож бараа үйлчилгээний зардалд 372,550.4 мянган төгрөгийг зарцуулж 183,307.7 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

2.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны хуульд заасны дагуу хуульд заасан хугацаанд жил, улирал, сар, тухай бүр оруулах мэдээллийг оруулсан байна. Байгууллагын цахим хуудас www.iag.mn сайтад шилэн дансны цэсийг холбосон. Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын дагуу Одон орон геофизикийн хүрээлэн нь www.shilendans.gov.mn цахим сайтад I) төсөв/гүйцэтгэл; II) хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт; III) бусад; цэсэнд хуульд заасан хугацааны дагуу мэдээлэх үүрэгтэй. Тус хүрээлэн 2017 онд шилэн дансны тухай хууль, журмын дагуу холбогдох мэдээллийг цахим хуудсанд мэдээлсэн ба Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолын хавсралт "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын 3.2.1. "худалдан авах ажиллагааны...жилийн тайланг энэ журмын 22 дугаар хавсралтад заасан маягтын дагуу дараа оны 1 дүгээр сарын 15-ны дотор тус тус цахимаар," мэдээлнэ заалтыг хэрэгжүүлээгүй байна.

2.8 Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу 10 дансанд эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд 44 хяналтын болон нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Аудитын гүйцэтгэлээр төлөвлөлтийн үе шатанд үр нөлөөтэй гэж авч үзсэн эрсдлүүдээс авлага, бараа материал, цалин хөлс, орлого, зардлын дансны гүйлгээтэй холбоотой зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ХЯЗГААРЛАЛТАЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

2.9 Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар

Одон орон геофизикийн хүрээлэнгийн 2017 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, цалин

хөлс, орлого, зардлын дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрлэн нарийвчилсан сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр шалгасан нарийвчилсан сорил нь тус байгууллагын нийт орлого, зардал, хөрөнгийн 60 хувийг эзэлж байна.

2.10 Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар

Аудитын явцад төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлого, дансдын нэгдсэн жагсаалт, нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэж гаргах аргачлалын дагуу ажил гүйлгээг бүртгэлд тусгасан байдал, дансны болон ерөнхий журнал, ерөнхий дэвтэр зэрэг хураангуй бичилтийг арга зүйн хувьд нягтлан үзэж санхүүгийн тайлангийн илэрхийлэлд үнэлэлт өгсөн. Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

2.10.1 Авлагын талаар

Татаас санхүүжилтийн авлага 182,766.9 мянган төгрөгийг тооцоо нийлсэн авлагаар баталгаажуулж бүртгэлд тусгаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ;" 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн баталгаажуулж ажиллах талаар зөвлөмж өгөв.

2.10.2 Бараа материалын талаар

Бараа материалд гар утас, Iphone 7, Iphone 7 plus зэрэг 5559.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бүртгэсэн нь Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалаар батлагдсан Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх зааврын Эргэлтийн хөрөнгө 4.9 "Дараах тохиолдолд хөрөнгийг эргэлтийн хөрөнгө гэж үзнэ. а/ байгууллагын үйл ажиллагааны циклийн хэвийн нөхцөлд ашиглахаар хүлээгдэж байгаа, эсвэл худалдан борлуулахаар эзэмшиж байгаа эсвэл б/ үндсэндээ худалдах зориулалттай юмуу богино хугацаатай эзэмшиж байгаа бөгөөд тайлангийн өдрөөс хойш арван хоёр сарын дотор ашиглахаар хүлээгдэж байгаа; эсвэл в/ мөнгө болон мөнгөтэй адилтгах хөрөнгө Бусад бүх хөрөнгө нь эргэлтийн бус гэж ангилагдана." заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх зааврын дагуу хөрөнгийг ангилж бүртгэх зөвлөмж өгөв.

2.10.3 Үндсэн хөрөнгийн талаар

- Тайлант оны эхэн ба эцэст элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн 1,422,603.9 мянган төгрөгийн анхны өртөгтэй хөрөнгүүд байна. Энэ нь УСНББОУС 17 "Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үндсэн хөрөнгө цаашид ашиглагдахаар байвал дахин үнэлгээ хийх" заалтыг мөрдөөгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Анхны өртгөө нөхсөн үндсэн хөрөнгө цаашид ашиглагдахаар байвал хөрөнгийн дахин үнэлгээ хийх зөвлөмж өгөв.

- Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлд 11 нэр төрлийн нийт 60,435.6 мянган төгрөгийн бараа материалыг нэг бүрийн үнээр давхардуулан бүртгэсэн нь Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалаар батлагдсан "Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх заавар"-ын Эргэлтийн бус хөрөнгө 4.78-д "Үндсэн хөрөнгө гэдэг нь дараах биет хөрөнгө: а. Бүтээгдхүүн эсвэл үйлчилгээний үйлдвэрлэлт буюу нийлүүлэлтэнд, бусдад түрээслүүлэхээр эсвэл захиргааны зориулалтаар ашиглаж буй байгууллагын эзэмшиж байгаа: ба б. Нэгээс дээш тайлангийн хугацааны туршид ашиглагдахаар хүлээгдэж байгаа хөрөнгө" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Хөрөнгийг зөв ангилж бүртгэлд тусгах зөвлөмж өгөв.

2.10.4 Хөрөнгийн дахин үнэлгээний талаар

Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү дансанд төвийн салбар (88,642.9) мянга, хөдөө орон нутгийн салбарууд 74,378.8 мянга, нэгтгэл тайланд (14,264.1) мянга төгрөгийг бүртгэсэн нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан "Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын Дахин үнэлгээ 4.42 "Дахин үнэлгээний үр дүнд хөрөнгийн дансны үнэ нэмэгдсэн хэмжээгээр дахин үнэлгээний нэмэгдэл дансны кредитэд бичнэ. 4.43 Дахин үнэлгээний үр дүнд хөрөнгийн дансны үнэ буурсан тохиолдолд буурсан хэмжээг зардал гэж хүлээн зөвшөөрнө. 4.44 Дахин үнэлгээний нэмэгдлийг хэрэгжсэн үед нь хуримтлагдсан үр дүн данс руу шилжүүлнэ." заалтууд мөн Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалын 3 дугаар хэсгээр Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх зааврын 4.20 үндсэн хөрөнгийн дахин үнэлгээгээр гарсан үнийн өсөлтийг "Дахин үнэлгээний нэмэгдэл" гэсэн хэсэгт үзүүллэнэ." заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:

Хөрөнгийн дахин үнэлгээг холбогдох журмын дагуу бүртгэж байх зөвлөмж өгөв.

2.10.5 Зардлын талаар

- Банкны шимтгэлийн зардал 16.5 мянган төгрөгийг орлого дансанд бүртгэсэн нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан "Нягтлан бодох

бүртгэлийн дансны заавар"-ын 2.1. "Орлого гэдэг нь тайлангийн хугацаанд байгууллагын ердийн үйл ажиллагааны үр дүнд орж ирж байгаа бөгөөд өмчлөгчдөөс оруулах нэмэгдэл хөрөнгө оруулалтаас бусад цэвэр хөрөнгө/өмчийг нэмэгдүүлэх, эдийн засгийн өгөөж буюу үйлчилгээний чадавхиас орох нийт орлогын урсгал юм." заалтад нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Нягтлан бодох бүртгэлийн дансны зааврыг мөрдөж ажиллах зөвлөмж өгөв.

- Гэрээт 6 ажилчдад нийт 1,425.0 мянган төгрөгийн төрийн албан хаагчдын мөнгөн урамшуулал олгосон нь Монгол Улсын Их Хурлын 2017 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн 67 дугаар тогтоолын 1/2017 оны төсвийн жилд төрийн өндөр албан тушаалтан, шүүгч, прокуророос бусад төрийн албан хаагчид 300000 төгрөгийн ажлын үр дүнгийн урамшуулал олгох; заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Холбогдох тогтоол шийдвэрийг хэрэгжүүлж ажиллахыг зөвлөн зөрчлийг арилгах төлбөрийн акт тогтоов.

2.10.6 Цалин хөлсний талаар

- Гэрээт ажилчдын цалин хөлснөөс нийт 31,529.9 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг тооцож төсөвт төвлөрүүлээгүй нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 2-д "Нийгмийн даатгалд дор дурьдсан ажилтан албан журмаар даатгуулна: 1/өмчийн бүх хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус, шашны болон бусад байгууллага, иргэнтэй байгуулсан хөдөлмөрийн гэрээ болон Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд заасан гэрээний дагуу ажиллаж байгаа Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн;" гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:

Нийгмийн даатгалын тухай хуулийг хэрэгжүүлж ажиллан зөвлөмж өгөв.

- Ажилтан албан хаагчдын ээлжийн амралтыг бодохдоо унаа хоолны мөнгийг дундаж цалинд оруулж тооцон 2,557.1 мянган төгрөгийг илүү олгосон нь Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2005 оны 55 дугаар тушаалаар батлагдсан Дундаж цалин хөлс тодорхойлох журмын Ажилтанд олгож байгаа бүр төрлийн /жирэмсний болон амаржсаны, хөдөлмөрийн чадвараа алдсаны, ажилгүйдлийн, тэтгэвэрт гарах үеийн ажилтанд олгох гэх мэт/ тэтгэмжүүд, нөхөх олговор, хөнгөлөлтийн орлого, /унаа, түлш, байр, хоолны үнийн хөнгөлөлт/-ыг ажилтны цалин хөлсний бүрэлдэхүүнд оруулахгүй." заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:

Цаашид ээлжийн амралтыг холбогдох журмын дагуу тооцож байхыг зөвлөн, зөрчлийг арилгах төлбөрийн акт тогтоов.

2.11 Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар

Материаллаг бус 31,529.9 мянган төгрөгийн алдааг залруулах боломжгүй байна.

2.12 Анхаарал татахуйц бусад чухал асуудал

Одон орон геофизикийн хүрээлэнгийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын явцад анхаарал татахуйц чухал асуудал гараагүй болно.

2.13 Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд

Одон орон геофизикийн хүрээлэнгийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.

2.14 Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

Одон орон геофизикийн хүрээлэнгийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 425,202.3 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэнээс 126,648.2 мянган төгрөгийн алдааг тайлант хугацаанд залруулуулж 3,982.1 мянган төгрөгийн зөрчлийг нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоож санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг батламж мэдэгдэл хангагдаагүй 7 зөвлөмжийг Менежментийн захидлаар байгууллагын удирдлагад хүргүүлэв.

2.15 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Одон орон, геофизикийн хүрээлэн нь 2016 онд түүвэр аудитад хамрагдсан бөгөөд тус аудитаар төлбөрийн акт тогтоогдоогүй ба дүгнэлт зөвлөмж өгөөгүй байна.

2.16 Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эе тасуулал. Одон орон геофизикийн хүрээлэнгийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ХЯЗГААРЛАЛТТАЙ
САНАЛ ДҮГНЭЛТ


Одон орон геофизикийн хүрээлэнгийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

Аудитлагдсан санхүүгийн тайлан 15 хуудас, хавсралтууд 9 хуудсыг тус тус хавсаргав.

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

"ЦЭГЦТӨВ БОГД АУДИТ" ХХК-ИЙН
АУДИТЫН БАГИЙН АХЛАГЧ.....  Н.ЦЭРЭНХАНД Огноо:

БЭЛТГЭСЭН:

"ЦЭГЦТӨВ БОГД АУДИТ" ХХК-ИЙН АУДИТОР  Б.БОЛОРМАА Огноо:

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ХЯЗГААРЛАЛТАЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ХЯЗГААРЛАЛТАЙ



YAG
УНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

ОДОН ОРОН ГЕОФИЗИКИЙН ХҮРЭЭЛЭН

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:

САГ-ын захирал, Тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663
Цахимхаяг: naranchimegts@audit.mn

Аудитын менежер: С.Оюунгэрэл
Утас: 261885
Цахимхаяг: oyungerels@audit.gov.mn

ТАБ-ын хаяг: ЗГ-ын IV байр
Бага тойруу 6, Улаанбаатар 46

“Цэгцтөв богд Аудит” ХХК-ийн
Аудитын багийн ахлагч Н.Цэрэнханд
Утас: 99901517

Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:

Асуудал 1	
Авлагын талаар.....	1
Асуудал 2	
Бараа материалын талаар.....	2
Асуудал 3	
Үндсэн хөрөнгийн талаар.....	3

Тэргүүлэх ач холбогдол №2 зүйлс:

Асуудал 4.	
Дахин үнэлгээ.....	4
Асуудал 5.	
Зардлын талаар	5

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
**ХЯЗГААРЛАЛТАЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

Улаанбаатар хот

3. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Одон орон геофизикийн хүрээлэнгийн удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгдсэн ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Энэ нь Одон орон геофизикийн хүрээлэнгийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Одон орон геофизикийн хүрээлэнгийн санхүүгийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ХЯЗГААРЛАЛТАЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ХЯЗГААРЛАЛТАЙ

